


*Профессор Францис Вүүдмэн Кливизийн
мэндэлсний 100 жилийн ойд энэхүү дугаарыг зориулав.*





Francis W. Cleaves

FOREWORD

Francis Woodman Cleaves (1911-1995) was born and raised in Boston, and received his undergraduate degree in Classics from Dartmouth College. He then enrolled in the graduate program in Comparative Philology at Harvard, but transferred to the study of Far Eastern Languages in the mid-1930s. With the support of the Harvard-Yenching Institute, he spent 1935-1938 in Paris studying Mongolian and other Central Asian languages with Paul Pelliot, after which he proceeded to Peking, where for three years he continued to study Chinese and Mongolian. In 1941 he returned to Harvard and began teaching Chinese in the Department of Far Eastern Languages. During the following year he received his Ph.D., with a dissertation entitled "A Sino-Mongolian Inscription on 1362," and offered Harvard's first course on the Mongolian language.

Cleaves is widely recognized as one of the chief founding figures of Mongolian studies in the United States. His many articles, famously erudite and philologically rigorous, remain of value to specialists today, and his translation of the *Secret History of the Mongols* stands as a monument to his dedication to bringing classic texts to English-speaking readers. Cleaves's long career at Harvard, where he taught until the mid-1980s, allowed him the opportunity to train younger scholars in the field, such as David Farquhar, Joseph Fletcher, Elizabeth Endicott-West, and Christopher Atwood. But he was hardly the typical Harvard professor, preferring to live on his farm in New Hampshire, some three hours north of Boston, where he maintained a large community of cattle, horses, and dogs. His departmental colleagues believed that he chose this pastoral life "in emulation of the Mongol herdsmen whose exploits he chronicled."

The tradition of Mongolian studies established by Professor Cleaves is preserved still at Harvard, where courses in classical Mongolian language continue to be offered. His greatest continuing contribution is doubtless the fine collection of several hundred Mongolian- and Manchu-language books and manuscripts he collected for the Harvard-Yenching Library. These materials serve today to provide inspiration for a new generation of Mongolists. Likewise, this special issue of *Acta Mongolica* reminds us of the timeless, tremendous contributions made to Mongolian studies by this remarkable scholar.

Mark C. Elliott

Mark Schwartz

/Professor of Chinese and Inner Asian History, Harvard University/

ЭРДЭМ СУДЛАЛ, ЁСЗҮЙН ХҮРШГҮЙ ӨНДӨР СТАНДАРТТАЙ ХҮН

Ж. Бат-Ирээдүй*

Монголч эрдэмтэн Францис Вүүдмэн Кливиз 1911 оны 7 дугаар сарын 14 ний өдөр АНУ-ын Бостон хотод мэндэлжээ. АНУ-ын монгол, хятад судлалыг үндэслэгч Ф.В.Кливиз бээр өөрийнхөө судалгааны гол чигийг Монголын эртний болон дунд үеийн монгол хэлийг судлахад зориулсан бөгөөд энэ нь түүний Хятадад очиж цуглуулж судалсан хятад монгол бичээсийг нарийн нямбай судлаж хэвлүүлсэн судалгааны бүтээлүүдээс харагддаг билээ.

Түүний хэлшинжлэлийн авьяас нь нэлээд залуугаас нь тодорч байсан бөгөөд тухайлбал Нийдхам гольфийн клубын цохиур зөөгчдийн ахлагч хийж байхдаа бусад ахлагч нараасаа итали хэл маш хурдан сайн сурч байснаар мэдэгдэж байжээ.

Тэрбээр 1933 онд Дартмаутийн дээд сургуулийн сонгодог хэлний ангид суралцан төгсөж дараа нь хэлшинжлэлийн ухааны мастерын зэрэг хамгаалжээ. Дараа нь тэрбээр эхлээд Харвардын Их сургуулийн харьцуулсан сонгодог хэлбичгийн ангид докторын зэрэг хамгаалахаар сурч эхлэсэн боловч жилийн дараа дорно дахины хэлшинжлэлийн тэнхим рүү шилжсэн байна. Ингэж судалгааны чиглэлээ өөрчилж шилжсэн нь Боилстон Холл гэдэг танхимын үүдэнд байдаг хятад бичээсийг үзэж судлах зорилгоос үүдэлтэй байжээ.

1935 онд Харвард Енчинг Хүрээлэн байгуулагдсанаас хойш 7 жилийн дараа 24 настай Кливиз Дорно дахин судлалын тэнхимийн докторант тэрбээр тус хүрээлэнгийн 6 жилийн тэтгэлэгт хөтөлбөрт шалгарч Поль Пеллиотын удирдлага доор Парисын Сорбоны Их Сургуульд монгол, хятад, араб судлалаар сурахаар хүлгийн жолоо залжээ. Тэрбээр энд 1936-1938 онд суралцсан байна.

Сүүлийн гурван жил буюу 1938-1945 онд БНХАУ-ын Бээжин хот дахь Хятад-Энэтхэг судлалын хүрээлэнд Антойн Мостартын удирдлага дор хятад монгол судлалаар ажилласан байна. Антойн Мостарт бол түүний багш төдийгүй сайн нөхөр нь байжээ.

Бээжинд байх хугацаандаа үүсгэн байгуулагч Стаел Холстенийг нас барсанаас хойш зогсонги шатандаа ороод байсан Хятад Энэтхэг судлалын хүрээлэнг сэргээж өгсөн байна. Энд мөн буддийн шашны олон номыг индекс хийх, каталогжуулах төслийг санаачлан, ажиллах хүн хүчин бий болгожээ.

Кливизийн монгол, хятадын судалгаанаас гадна Харвардын их сургуулийн ном сан буюу Харванд Енчингийн Номын сангийн монгол, манж номыг бүрдүүлэхэд оруулсан түүний хувь нэмрийг судлаачид өндрөөр үнэлдэг билээ. Одоогийн Харвардын Их Сургуулийн манж монгол номын сан хөмрөг бол дэлхийд ховорт тооцогдох бөгөөд ойролцоогоор 306 ном, 112 гар бичмэл, зуу зуун 18-19 зууны архивын ховор нандин эх баримтууд хадгалагдаж байгаа нь АНУ-д нэлээд дээгүүрт орж, Парис, Лондон дахь сан хөмрөгтэй эн зэрэгцэж, Санкт-Пэтэрсбург, Токио, Бээжингийн цуглуулгын ард жагсах байх.

Хятадад суралцсан энэ гурван жилийн хугацаанд Бээжингийн номын дэлгүүрийг гүйцээж, Чин улсын үеэс хойших монгол, манж судлалын хятад хэлээрх ном болон монгол, манж хэлээрх сонин содон ном эрчимтэй цуглуулахдаа их авьяастай байжээ. Энэ үеэр авсан номоороо дараа нь манж монгол цуглуулгыг бүрдүүлсэн байна. Номыг худалдаж авахдаа маш чамбай сонголт хийж байж, тухайн үед бусад хүний хувьд хог новш шиг санагддаг байсан

* - МУИС-ын Монгол Судлалын Хүрээлэн

номын үнэ цэнийг нь мэддэг мэдэрдэг, манж монгол хэл сайн мэддэг байсан учир маш сайн сонголт хийдэг “худалдан авагч” байжээ.

Хэдийгээр тэр өөрийнхөө худалдаж авсан номын талаар ямар нэгэн мэдээлэл, жагсаалт үлдээгээгүй боловч цуглуулсан номын тоо хэмжээ болон чанар нь гайхалтай байсан гэж судлаачид үздэг байна.

Миний бие 2011 оны 10-р сард Харвардын Их Сургуульд зочлохдоо уг номуудын зах зухаас нүдээр үзэж, гараар барьж түүний үлдээсэн өв хөрөнгийг шүтэн биширсэн..

1941 онд АНУ-д эргэж ирээд Харвардад Дорно дахины судлалын тэнхимд хятад хэл зааж эхэлжээ. Бээжинд сууж байхдаа хэдийгээр диссертацаа хэвлэж дуусгасан боловч ном зөөж тээвэрлэх явцад бичсэн ажлаа алдсан учир диссертацаа шинээр бичиж эхлэсэн юм байна. Харин энэ алдагдсан ном болон диссертаци нь сүүлд дайны дараа Японы Кобэгоос олджээ. Энэ үеэс монгол хэлийг маш шуурхай сурч эхлэсэн гэж үздэг.

Тэрбээр тэнгисийн цэрэгт бүртгүүлж Номхон далайд цэргийн алба хааж байсан. Дэлхийн 2 дугаар дайны дараа Хятадад буцаж Хятадын хойд нутгаар суурьшиж байсан япон иргэдийг нутагт нь буцаах ажлыг хариуцаж байсан тэр үеэр үлдэж хаягдсан номыг цуглуулан армийн ачааны машинд ачиж Харвардад илгээж эхлэжээ.

Энэ удаа зөвхөн номын дэлгүүрээр хязгаарласангүй, хятадын хойд нутагт амьдарч байсан япон хүмүүсийн гэрт байсан номыг цуглуулж эхлэсэн байна. Учир нь тухайн үеийн япончууд хятадын нутгаас зугтан гарахдаа өөрсдийн номын санг хаяж явсантай холбоотой асар их ном үлдэж байжээ.

Тухайн үеийн Япончуудын Манжийг сонирхох сонирхол их хүчтэй байсан тул энэ үеийн ихэнх хувийн номын сан манж хэлээр бичигдсэн номтой байж. Энэхүү хоёр удаагийн цуглуулгаар бүтсэн манж, монгол ном нь Харвардын Енчинг Инститүтийн номын сангийн томоохон сан хөмрөг болжээ.

Номын огноог харвал тус номын сангийн цуглуулга 1950-иад оны эхэн үеэс хэрэглээнд орж байж, 1960 он гэхэд Кливизийн цуглуулсан номын тал нь очсон бөгөөд тал хувь нь өөрийнх нь, хувийн номын санд данстай байжээ. Кливизийн хувийн цуглуулгын талаар нарийвчилсан бүртгэл мэдээлэл байдаггүй бөгөөд ямар ч байсан тэрбээр өөрийн цуглуулгын ихэнхийг Харвард Енчинг Инститүтийн номын санд өгч, оюутан шавь нартаа уншуулж, зээлүүлж хэрэглүүлдэг байжээ. Тэдний нэг нь тухайн үедээ түүний ажлыг үргэлжлүүлэгч монгол судлаач Жозеф Флэчэр байсан бөгөөд харамсалтай нь тэрбээр өвчний учир эрт нас барсан байна. Яагаад тийм их манж ном цуглуулсан нь одоо хүртэл тодорхойгүй байна. Учир нь манж ном бол түүний хувийн судалгаатай бараг холбоогүй гэж үздэг. Гэвч түүний алсыг харж ийм их ном цуглуулсанд нь өнөөгийн эрдэмтэн мэргэд түүний хүч хөдөлмөр, алсын хараанд нь талархаж байдаг билээ.

1946 онд Америктаа буцаж Харвардын Их Сургуулийн дорнодахины судлалын салбарт дэд профессороос профессор хүртэл албан тушаалд ажиллаж байгаад 1980 онд өндөр насны амралтанд гарчээ.

Тэрбээр Харвардын их сургуульд 30 гаруй жил ажиллахдаа дорнодахины түүх, хэлбичгийн судлалын хичээл зааж байснаас гадна XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалт бичгүүдийг нарийн судласан хүн. Тухайлбал, түүний анхны бүтээл болох “Индү вангийн дурсгалд зориулсан хөшөөний хятад-монгол бичээс”, (1362), “Бээжингийн хааны ордны музейд хадгалагдаж байгаа “Тахимдуу ном”-ын тухай, судлал зэргийг дурдаж болно.

Мөн “Монголын нууц товчоон”-ы англи тайлбартай орчуулга, XIII-XIV зууны дурсгалт бичгүүдийн олон сонирхолтой үг хэллэгийг тайлбарлаж, эрдэм шинжилгээний олон үгүүлэл нийтлүүлсэн юм.

1947 оноос эхлэн “Азийн судлалын Харвард сэтгүүл”-ийн эрхлэгчээр, 1952 оноос “Монгол бичгийн дурсгал” цуврал номын эрхлэгчээр ажиллаж, “Алтан товч”, “Болор эрх”, “Монгол зурхай” зэрэг олон чамбай бүтээл хэвлүүлсэн дэлхийд нэртэй монголч эрдэмтэн билээ. Түүнийг нас барсны дараа түүний хэвлүүлсэнтэй тэнцэхүйц хэмжээний хэвлэгдээгүй бүтээлүүд үлдсэний дотор Монголын Нууц товчооны орчуулгатай холбоотой олон үгүүлэл үлджээ.

Тэрбээр багшлах маш дуртай байсан бөгөөд тухайлбал түүнийг залгамжлан монгол хэл, төв азийн соёл зааж байсан Жозеф Флечер золгүй явдлаар нас барж, “замын дундаас буцсаны” дараа ямар ч төвөг учруулалгүй, үнэ хөлсгүйгээр шууд ажлыг нь үргэлжлүүлэн хийж 7 хоногт 2 удаа хаа байсан Шинэ Хампширийн фермээсээ Бостонд ирж хичээл зааж байжээ.

Түүний оюутнуудаа гэх сайхан сэтгэл нь тэднийг хооронд нь хааяа уулзуулж учруулж судалгаа шинжилгээний талаар ярилцахад хүргэж байжээ. Тэрбээр фермдээ ганцаараа үхэр, морь, маш олон нохойтойгоо амьдардаг, амьтанд маш хайртай хүн байсан бөгөөд, хүүхэд байхдаа могой, үмхий хүрэн, баавгайн бамбарууш гэртээ авчирч тэжээж байжээ. Түүний амьтдыг зарж үрээгүй харин хамгаалж үлдээсэн байна. Фермийн зорилго нь зарах зорилготой биш монгол малчны амьдралыг өөрийн бие дээр туршиж амьдрахыг хүсдэг байсан түүний хүсэл мөрөөдөлтэй холбоотой байсан ажээ.

Тэрбээр орчин цагийн техник хэрэгсэлд ихэд дургүй нэгэн байж, зөвхөн утас хэрэглэдэг байсан бөгөөд уулзахын тулд захиа бичих юм уу өөр дээр нь очихоос өөр замгүй байжээ.

Түүний баримталдаг эрдэм шинжилгээний гол зарчим бол нягт нямбай байх гагц зорилт тавьдаг байсан. Тэр зөвхөн оюутнууддаа төдийгүй бусад судлаачдаа бүх ишлэлийг яг таг орчуулж байх шаардлага тавьдаг байж. Өөрөө орос хэлээрх ишлэл татахдаа гарамгай судлаач байсан байна.

Энэ хүн бол эрдмийн төдийгүй ёс зүйн хүршгүй өндөр стандартын шаардлагыг өөртөө тавьсан хатуу үзэл бодолтой хүн байсан бөгөөд энэ нь зөвхөн эрдмийн ажил төдийгүй амьдралд баримталсан зарчим, үйл хэргээс нь харагддаг байна. Түүний энэ зан чанар нь америкчуудад Самуэл Жонсон гэдэг хүнийг санагдуулдаг бөгөөд өөрөө ч энэ хүнийг дуурайж амьдарчээ.

Тэрбээр 1995 оны 12 дугаар сарын 31 нд Шинэ Хампширэд насан өөд болжээ. Кливиз насаараа гэрлээгүй бөгөөд насан өөд болтлоо ах Бэртрам, эгч Марсиа Никэрсон нарын халамжинд амьдарч байжээ.

Эрдэм судлал, ёсзүйн хүршгүй өндөр стандарттай монголч эрдэмтэн энэ хүний мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл болон бусад судалгааны өгүүллүүдээс бүрдсэн энэхүү эрдмийн бичгийг эрдэмтэн судлаачдын мэлмийд өргөн барьж байна.

Ашигласан материал:

- Treasures of the Yenching, 75th Anniversary of the Exhibition Catalogue, Cambridge, Massachusetts, 2003
- Kanda Nobuo et al., eds., The Bordered Red Banner Archives in the Toyo Bunko: Introduction and Catalogue (Tokyo, 2001)
- Kanda, “Present State of Preservation of Manchu”